



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/37

Өмнөдэлгэр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.1 дэх заалт, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын “Аяга таваг угаагч автомат машин нийлүүлэх ерөнхий боловсролын сургуулийн жагсаалт”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Боловсролын Дэлхийн түншлэл олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн хүрээнд “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд шаардлагатай автомат аяга таваг угаагч худалдан авах, нийлүүлэх (угсралт, суурилуулалт, хүргэлт)” СХОГ-2025/221 тоот гэрээний дагуу “Дельфин партнерс” ХХК-иас нийлүүлсэн автомат аяга таваг угаагчийг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Ч.Хишигтогтох (Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга)

Гишүүд: М.Алтантуяа (Нягтлан бодогч)
Д.Даваасүрэн (Нярав)
М.Лхагвасүрэн (Ахлах тогооч)

Нарийн бичгийн дарга: П.Нямсүрэн (Архив, бичиг хэргийн ажилтан)

2.Автомат аяга таваг угаагчийг хүлээн авах ажлыг зохион байгуулж, удирдлагаар ханган, бараа хүлээн авсан баримтыг санхүүгийн баримт бичгийн шаардлагын дагуу бүрэн гүйцэт бүрдүүлж, баталгаажуулах үйл явцад хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Ч.Хишигтогтох)-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.СУГАРРАГЧАА

